



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/295

Хэрлэн сум

Уст цэгийн тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт дахь Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2019 онд хийгдэх Хэрлэн голын сав газар, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт уст цэгийн тооллогын ажлыг сав газрын захиргаатай хамтран зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2 Тооллогын явцад уст цэгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллахыг Сав газрын захиргаадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тооллогын ажилд хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэж мэдээллийн санд бүртгэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА